



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ**

2016 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 1129

Улаанбаатар хот

Г

Г

**Эрх шилжүүлэх тухай**


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр 2016 онд худалдан авах вакцин, биобэлдмэл, зүү тариур худалдан авах ЭМСЯ-В/2016/01 тендерийн Багц-2 буюу Хачигт энцефалитын эсрэг вакцин, багц 6 буюу Сальмонеллёзын нян залгиур, Багц 7 буюу Балнадын нян залгиур, багц 13 буюу Цусан суулгын олон цэнт нян запгиур, багц 15 буюу Боомын эсрэг иммуноглобулин, багц 16 буюу Страфилококкын анатоксин худалдан авах 141,823,000 /Нэг зуун дэчин нэгэн сая найман зуун хорин гурван мянга/ төгрөгийн төсвийн зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих/-ийг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д даалгасугай.


3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан/-т даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080453



## АЙЛЧЛАЛ ХИЙХ УДИРДАЛ

Нэг. Зорилго

БНХАУ-ын тэй танилцан, туршлага судалж, Монгол Хятадын хамтын ажиллагаа бий болгох

Хоёр. Арга хэмжээ болох газар

БНХАУ-ын Үндэсний эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн хороо, Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төв

Гурав. Хугацаа

2016 оны 04 дүгээр сарын 20-22

Дөрөв. Санхүүжилт

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгүүдийн олон улсын холбоо

Тав. Үйл ажиллагааны чиглэл

- Хятадын ӨХУСТ-тэй танилцах
- Хятадын халдварт бус өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийн талаар танилцах
- Хятадын өвчний тандалтын систем
- Халдварт өвчин, вирусын өвчний хүрээлэнгийн лабораторитой танилцах
- Орчны эрүүл мэндийн үндэсний хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй уулзаж, улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хэлэлцэх
- Архаг болон халдварт бус өвчний хяналт, урьдчилан сэргийлэх үндэсний төвийн мэргэжилтнүүдтэй хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулах

Зургаа. Хүрэх үр дүн

- Хятадын Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвтэй танилцаж, халдварт бус өвчний хяналт, урьдчилан сэргийлэлт, өвчний тандалтын систем улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар туршлага судлана.
- Цаашдын хамтын ажиллагааны хүрээнд санал солилцно.
- Үндэсний эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн хорооны үйл ажиллагаатай танилцаж, хамтын ажиллагааны хүрээнд санал солилцно.